

**ХЯНАЛТ, БҮРДҮҮЛЭЛТИЙН ГАЗРЫН ГААЛИЙН УЛСЫН БАЙЦААГЧ М.ЛХАГВАЧУЛУУНЫ 2024 ОНЫ
ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				Эхэлсэн дууссан хугацаа	Биелэлтийн хувь
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)			
	1	2	3	4	5	6	7	
Зорилт 1. Олон улсын хууль ёсны худалдааг хөнгөвчлөх, түүний аюулгүй байдлыг хамгаалах								
1	Гаалийн итгэмжлэгдсэн тээвэрлэгчид тавих хяналт	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-	1. license.mn-ээр ирүүлсэн хүсэлтийг шалгаж, МЗХ-д танилцуулж шийдвэрлүүлсэн байна. 2. ГИТ-ийн талаар танилцуулга бэлтгэж, удирдлагыг мэдээллээр хангасан байна. 3. ГТСМТТ УҮГ-тай license.mn-ийн хяналтыг сайжруулах чиглэлээр хамтран ажилласан байна.	НЭГ.Гаалийн тухай хууль тогтоомжийн дагуу тээвэрлэгч байгууллагад олгох гаалийн итгэмжлэл авах хүсэлтэй аж ахуйн нэгж гаалийн хууль тогтоомжид заасан шаардлагуудыг хангасан тохиолдолд гаалийн удирдах төв байгууллагад цахимаар хүсэлт гарган, шийдвэрлүүлэх боломж нээлттэй байдаг. ГЕГ-ын даргын 2022 оны "Шалгуур батлах тухай" А/338 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Тээвэрлэгч байгууллагад гаалийн итгэмжлэл олгох шалгуур"-ыг үндэслэн аж ахуйн нэгжээс "тусгай зөвшөөрлийн цахим систем" буюу license.mof.gov.mn цахим системийг ашиглан ирүүлсэн хүсэлтийг хүлээн авч хянаад: 1.2024.01.22-ны өдрийн МЗХ-д 70 ААН; 2.2024.03.04-ний өдрийн МЗХ-д 27 ААН; 3.2024.05.13-ны өдрийн МЗХ-д 33 ААН; 4.2024.06.14-ний өдрийн МЗХ-д 23 ААН; 5.2024.09.19-ний өдрийн МЗХ-д 37 ААН; 6. 2024.10.24-ний өдрийн МЗХ-д 9 ААН. ААН-ийн асуудлыг Мэргэжлийн зөвлөлийн хуралдаанд танилцуулж шийдвэрлүүлсэн. Мөн 2024 оны 12 дугаар сарын МЗХ-д 35 ААН-ийн хүсэлтийг танилцуулж, шийдвэрлүүлэхээр бэлтгэсэн. Тээвэрлэгч байгууллагад олгосон итгэмжлэлийн хугацаа сунгуулах хүсэлт ирүүлсэн 40 ААН, чиглэл нэмүүлэх хүсэлт ирүүлсэн 86 ААН-ийн хүсэлтийг судалж, ГЕГ-ын даргын тушаалаар батлуулсан. Мөн тээвэрлэгч байгууллагад олгосон итгэмжлэлийн хугацаа сунгуулах хүсэлт ирүүлсэн 6 ААН, чиглэл нэмүүлэх хүсэлт ирүүлсэн 17 ААН-ийн хүсэлтийг судалж, ГЕГ-ын даргын тушаалаар батлуулахаар ажиллаж байна. Тайлан хугацаанд ГЕГ-ын МЗХ-д танилцуулж, шийдвэрлүүлсэн 199 ААН-ийн Ерөнхий мэдээллийн 9, Гаалийн хяналтын мэдээллийн 6, Тайлбарын 3, ГЕГ-ын даргын шийдвэр гэсэн мэдээллүүдийг тус бүр оруулж,	04.02-11.30	91	

				тээвэрлэгчийн санг баяжуулсан. Мөн тээврийн хэрэгслүүдийг тус бүр програмд бүртгэн, ГИТ наалт олгосон. ГИТ ААН-ээс ирүүлсэн тээврийн хэрэгсэл нэмүүлэх, хасуулах, чиглэл нэмүүлэх 1201 хүсэлтийг шалгаж, тухай бүр CAIS-д нэмэлт өөрчлөлтүүдийг оруулсан. ХОЁР. Монгол Улсын ЗТХ-ийн сайдаас 2024.05.21-ний өдрийн 01/2241 дугаартай албан бичгийн хавсралтаар Сангийн яаманд хүргүүлсэн "Улс хооронд байнгын ачаа тээврийн зөвшөөрлийн бичиг олгох, тээвэрлэлтийн үйл ажиллагааг зохион байгуулах, хяналт тавих журам"-ыг батлах тухай ЗГ-ын тогтоолын төслийг 2024.06.07-ны өдөр хүлээн авч танилцсан. Журмын төсөлд оруулах нийт 13 санал боловсруулж ГЕГ-ын дэд даргад 2024.06.07-ны өдөр танилцуулсан. Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын 2011 оны Автотээврийн хэлэлцээрийн 3.1 "Хэлэлцэн тохирогч нэг талын автомашин Хэлэлцэн тохирогч нөгөө талын нутаг дэвсгэрт нэвтрэхдээ эрх бүхий байгууллагаас олгох зорчих зөвшөөрөл эхсүл онцгой зөвшөөрөл авна"-д заасны дагуу Авто тээврийн үндэсний төв хил нэвтрэх С зөвшөөрлийг улиралд нэг удаа олгодог бөгөөд С зөвшөөрөлтэй тээврийн хэрэгсэл БНХАУ-тай хиллэсэн хилийн боомтоор улс хооронд тээвэрлэлт гүйцэтгэж байна. Гаалийн тухай хуулийн 2711 дүгээр зүйлийн 2711.1.16 дахь заалт, Гаалийн ерөнхий газрын даргын 2022 оны "Шалгуур батлах тухай" А/338 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Тээвэрлэгч байгууллагад гаалийн итгэмжлэл олгох шалгуур"-ын 2.1 дэх хэсгийг үндэслэн тээвэрлэгч аж ахуйн нэгжүүдэд 3 жил хүртэлх хугацаагаар гаалийн итгэмжлэл олгодог ба Авто тээврийн үндэсний төвөөс олгосон хил нэвтрэх С зөвшөөрлийг улирал тутам олгодог тул гаалийн байгууллага гаалийн итгэмжлэл олгохдоо С зөвшөөрөлтэй байх шаардлага тавьдаггүй. Ийм учраас дээрх журамд "2.3.7.Тээвэрлэгч байгууллагад гаалийн удирдах төв байгууллагаас олгодог итгэмжлэлтэй байх." гэсэн заалт шинээр нэмж оруулах саналаа танилцуулж, нэгтгэсэн саналыг 2024.06.07-ны өдрийн 02/2325 дугаартай албан бичгээр Сангийн яамны ТНБД-д хүргүүлсэн. -Гаалийн байгууллагаас ГИТ-д тавьж байгаа хяналт, эрх зүйн зохицуулалтай холбоотой РРТ бэлтгэж, удирдлагад 2024 оны 1 дүгээр сард танилцуулж, мэдээлэл өгсөн. Мөн Мэргэжлийн зөвлөлийн хуралд ГИТ-ийн мэддээллийг тухай РРТ бэлтгэж, танилцуулсан. ГУРАВ. СМТТ УТҮГ-т хүргүүлж, шийдвэрлүүлсэн асуудлууд:		
--	--	--	--	--	--	--

					-Тээвэрлэгч байгууллагад олгодог гаалийн итгэмжлэл авсан ААН-үүд тээврийн хэрэгсэл нэмүүлэх хүсэлтээ цахимаар ирүүлэх боломж бүрдсэн; -Тээврийн хэрэгслийн мэдээлэл баталсан, идэвхгүй, баталгаажуулахаар илгээсэн төлвөөр сортолж харах боломжтой болсон. Мөн тээврийн хэрэгслийн жагсаалт дугаарлаж харагддаг болсон;		
					-Тээврийн хэрэгслийн мэдээлэл excel-рүү жагсаалтаар хөрвөдөг болсон; -Тээврийн хэрэгсэл нэмүүлэх хүсэлтээ тусгай зөвшөөрлийн цахим системээр илгээж, баталгаажсан төлөвт ороход ГИТ наалтанд агуулагддаг мэдээлэл бүхий QR үүсдэг болсон. СМТТ УТҮГ-т хүргүүлж, шийдвэрлүүлэхээр ажиллаж байгаа саналууд: -Тээвэрлэгч байгууллагын хүсэлт илгээсэн баталгаажуулахаар илгээсэн төлөвт байгаа тээврийн хэрэгслийн давхардлыг арилгах. Цахим системд Өөр ААН-д бүртгэлтэй гэх мэдээллийг зөвхөн баталгаажсан төлөвт байгаа тээврийн хэрэгсэлийг давхардсанаар бүртгэх.		
2	Бодлогын бичиг баримтын зорилт, арга хэмжээний хэрэгжилт	Хэрэгжилт, гүйцэтгэл эр	-	Бодлогын бичиг баримт, эрх зүйн актын биелэлт болон хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангах чиглэлд зохион байгуулсан арга хэмжээний биелэлтийг хариуцсан нэгжид хугацаанд нь хүргүүлсэн байна.	Дараах бодлогын бичиг баримт, эрх зүйн актын биелэлтийг гаргаж, ХХ-т сар бүр тогтмол хүргүүлсэн: Засгийн газрын тогтоол: -Худалдааг хөнгөвчлөх, уул уурхайн бус бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх талаар авах арга хэмжээний тухай 2023.05.17-ны өдрийн 178 дугаар тогтоолын 3.1 дэх заалт; Засгийн газрын тэмдэглэл: -"Зөвшөөрлийг цахимаар олгох ажлын явцын талаар" 2023.07.26-ны өдрийн 30 дугаар тэмдэглэлийн 1.1, 3.3 дахь заалт.	04.02-11.30	90
3	Үүрэг даалгаврын биелэлт	Хэрэгжилт, гүйцэтгэл эр	-	Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг цаг хугацаанд нь гүйцэтгэсэн байна.	Гаалийн итгэмжлэгдсэн тээвэрлэгчтэй холбоотой E-Дос системээр хуваарилагдсан 1201 албан бичгийг зохих журмын дагуу шийдвэрлэн холбогдох хариуг өгч ажилласан. Мэргэжлийн зөвлөлийн хурлаар өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлтийг тухай бүр ЗДАСП-аар илгээж ажилласан. ГИТ ААН-ийн хугацаа дууссан боловч итгэмжлэлээ сунгуулах хүсэлт ирүүлээгүй, хүчинтэй хугацаа дуусах дөхсөн 83 ААН-үүдрүү мэдэгдэл хүргүүлсэн.	04.02-11.30	95

4	Ажлын цаг ашиглалт	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-	Ажлын өдрийн өглөө орой бүр цаг бүртгэлийн нүүр таних төхөөрөмжид бүртгүүлж, томилолт, уулзалт зөвлөгөөн, хэлэлцүүлэгт оролцох, томилолтоор ажиллах, ээлжийн амралт, чөлөө авах хүсэлтийг CERP-д тухай бүр оруулан, илгээсэн байна.	Тайлант хугацаанд ажлын өдрийн өглөө орой бүр цаг бүртгэлийн нүүр таних төхөөрөмжид бүртгүүлсэн. 2024 оны эхний хагас жилд: Чөлөөний 2 хүсэлтийг CERP-д тухай бүр оруулан илгээж, хянуулсан. Мөн 4737 минут илүү цагаар ажилласан байна. Ажлаас хоцорсон, ажил тасалсан цаг байхгүй.	04.02-11.30	100

Хоёр. Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт

Д/д	Үүрэг даалгавар (арга хэмжээ)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлт ийн хувь
1	Ажлын хэсгийн хуралд оролцох	Хэрэгжилт гүйцэтгэлээр	-	ЭЗХЯ, ГХЯ-аас зохион байгуулах хуралд оролцох.	Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2023 оны А-47 дугаар тушаалаар Монгол Улс БНСУ хоорондын Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийг байгуулахтай холбогдуулан байгуулагдсан Үйлчилгээний худалдааны ажлын хэсгийн хэлэлцээ болон хуралд 2024.05.08-ны өдрийн 15 цаг, 2024.05.21-23-ны өдрүүдэд амжилттай оролцсон.	04.02-11.30	100
2	Танилцуулга бэлтгэх	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-	ГИТ холбоотой танилцуулга, мэдээлэл бэлтгэх, бусад цаг үеийн шинжтэй танилцуулга бэлтгэх.	Танилцуулга бэлтгэсэн, удирдлагыг шаардлагатай мэдээллээр хангаж ажилласан. ГИТ ААН-үүдийн байршил тогтоох /GPS/ системийг ШХТ-тэй хамтран нэгтгэх талаар судалгаа хийж, танилцуулга мэдээллийг бэлтгэсэн.	04.02-11.30	100

Гурав. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн дууссан хугацаа	Биелэлт ийн хувь
	1	2	3	4	5	6	7
1	Сургалтад хамрагдаж, мэдлэгээ дээшлүүлэх	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-	Богино болон дунд хугацааны сургалтад хамрагдсан байна.	Шинээр гарсан хууль, тогтоол, журам, зааврыг тухай бүр бие даан судалж, хууль эрх зүйн мэдлэгээ дээшлүүлсэн. Мөн Гаалийн ерөнхий газрын зохион байгуулалтын нэгжүүдээс долоо хоногийн баасан гараг бүрт зохион байгуулсан сургалтуудад хамрагдсан. Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулдаг 7:4:10 сургалтуудад хамрагдсан.	04.02-11.30	100
2	Гадаад хэлний гаалийн хэргийн мэдлэгээ дээшлүүлэх зорилгоор англи хэлийг бие даан суралцах	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-	Гаалийн хэргийн англи хэлний мэдлэг дээшилж, "Glossary of international trade and customs terms"-ыг судалсан байна.	Гаалийн хэргийн англи хэлний мэдлэгээ дээшлүүлэх зорилгоор "Glossary of international trade and customs terms"-ыг судалж байна. www.wccomd.org хаягаар гаалийн хэргийн мэдлэгээ дээшлүүлэх зэрэгцээ хэлний мэдлэгээ дээшлүүлж онлайн хичээлд хамрагдсан.	04.02-11.30	100

ТАЙЛАН ГАРГАСАН:

ХЯНАЛТ, БҮРДҮҮЛЭЛТИЙН ГАЗРЫН
ГААЛИЙН УЛСЫН БАЙЦААГЧ

.....


/М.ЛХАГВАЧУЛУУН/

2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 10-НЫ ӨДӨР

**ГААЛИЙН УЛСЫН БАЙЦААГЧ М.ЛХАГВАЧУЛУУНЫ 2024 ОНЫ АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР
ДҮН, МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС**

Байгууллагын нэр: Гаалийн ерөнхий газар
Нэгжийн нэр: Хяналт, бүрдүүлэлтийн газар

1. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний гүйцэтгэлд өгсөн оноо	Төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэсэн байдал	Нийлбэр оноо	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
	1	2	3	4	5
	Оноо	60 хүртэл	10 хүртэл	70 хүртэл	
Зорилт 1. “Олон улсын хууль ёсны худалдааг хөнгөвчлөх, түүний аюулгүй байдлыг хамгаалах”-ийг хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт					
1.	Гаалийн итгэмжлэгдсэн тээвэрлэгчид тавих хяналт.	50	5	55	
2.	Бодлогын бичиг баримтын зорилт, арга хэмжээний хэрэгжилт	55	5	60	
3.	Үүрэг даалгаврын биелэлт	55	5	60	
4.	Ажлын цаг ашиглалт	60	10	70	
Нэмэлт үүрэг даалгаврын биелэлт					
1	Ажлын хэсгийн хуралд оролцох	60	10	70	
2	Танилцуулга бэлтгэх	60	10	70	

2. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний биелэлтийн хувь	Нийт (15 хүртэл оноогоор)	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
	1	2	3	4
1	Сургалтад хамрагдаж, мэдлэгээ дээшлүүлэх	100	15	
2	Гадаад хэлний гаалийн хэргийн мэдлэгээ дээшлүүлэх зорилгоор англи хэлийг бие даан суралцах	80	12	

Дундаж оноо	13.5	
-------------	------	--

3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Нэгжийн даргын үнэлгээ)

Д/д	Үзүүлэлт	Нэгжийн даргын үнэлгээ (0-7 оноо)	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
	1	2	3
1.	Хандлага, ёс зүй	7	
2.	Дүн шинжилгээ хийх	6	
3.	Асуудал шийдвэрлэх	6	
4.	Хариуцлагатай байдал	7	
5.	Ажлын цаг ашиглалт	7	
Дундаж оноо		6.6	

4. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Хамт олны үнэлгээ)

Д/д	Үзүүлэлт	Хамт олны үнэлгээ (0-8 оноо)
	1	2
1.	Хандлага, ёс зүй	8
2.	Багаар ажиллах	8
3.	Харилцаа	8
Дундаж оноо		8

5. Гүйцэтгэлийн үнэлгээ

Д/д	Үнэлгээний үзүүлэлт	Үзүүлэлт тус бүрийн оноо
1.	Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт (Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт)	64.1
2.	Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт	13.5
3.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ	6.6

	(Нэгжийн даргын үнэлгээ)	
4.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Хамт олны үнэлгээ)	8
5.	Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт (Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)	
Нийт оноо = (Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо + Хандлага, ёс зүй, ур чадварын оноо (Нэгжийн даргын болон хамт олны үнэлгээ)) - Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо + Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу нэмсэн оноо		92.2

Үнэлгээ өгсөн:**Нэгжийн дарга:**

Хяналт, бүрдүүлэлтийн газрын даргын
албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

(Б.Даваасүрэн)

.....(огноо)

**Үнэлгээтэй танилцаж,
зөвшөөрсөн:****Төрийн жинхэнэ албан хаагч:**

Гаалийн улсын байцаагч

(М.Лхагвачулуун)

.....(огноо)

Үнэлгээг хянасан :**Үнэлгээний багийг төлөөлж ахлагч:**

Дэд даргын албан үүргийг түр
орлон гүйцэтгэгч

(Г.Энхтайван)

.....(огноо)

Үнэлгээний багийн нарийн бичгийн дарга:

Хүний нөөцийн хэлтсийн гаалийн улсын
ахлах байцаагч

(Ө.Тэгшээ)

.....(огноо)

Үнэлгээг баталгаажуулсан:**Төсвийн шууд захирагч**

Гаалийн ерөнхий газрын дарга

(Р.Отгонжаргал)

.....(огноо)